

### III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“KOMATSU D65E-12 бульдозерын дизель хөдөлгүүрийн их засварын ажил”

#### Мэдээлэл:

Хэнтий аймгийн “Бор-Өндөр” суман дахь “МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ -ийн харъяа “Бор-Өндөр” УБҮ -ийн “Баргилтын төмрийн хүдрийн ил уурхай”-д ашиглагдаж буй KOMATSU D65E төрлийн бульдозерын 6D125E-2 хөдөлгүүрийн их засварын ажил гүйцэтгэнэ.

Машин, техникийн тухай мэдээлэл:

- Машины модель: KOMATSU D65E
- Машины үйлдвэрлэсэн он: 2002
- Машины Ser No \*6556\*

Засварлах эд анги:

- 6D125E-2 дизель хөдөлгүүрийн их засварын ажил
- Хөдөлгүүрийн дугаар: SER No 75846
- Хөдөлгүүрийн ажилласан цаг: 12000 мотоцагаас дээш

Засварын ажил, хүргэлт, салгалт, угсралтын ажилд тавигдах шаардлага:

- Засварлах эд ангийг ажил үйлчилгээ худалдан авагчийн байранд гүйцэтгэж болно. Мөн ажил үйлчилгээ үзүүлэгч байгууллага өөрийн засварын газарт засварлах боломжтой.
- Хөдөлгүүрийн засварын ажлын үргэлжлэх хугацаа 45 хоногоос ихгүй байна.
- Засварын ажил гүйцэтгэгч талын байранд хийгдэх тохиолдолд дизель хөдөлгүүрийг засварын ажил гүйцэтгэх байгууллага тээвэрлэн авч явж өөрийн засварын байранд засварлана.
- Засварын ажлын гүйцэтгэлийн дараа дизель хөдөлгүүрийн үндсэн болон иж бүрдэл бологч эд анги (стартер, генератор, түлшний болон агаарын хоолой, ремень-оосор, хөдөлгүүрийн суурь, дэр жийрэг, турбогенератор түүний хоолой) -н шинэчлэл хийж сольсон, иж бүрдэлд угсрагдах бүхий л хэрэгсэл иж бүрэн угсрагдаж ирсэн байна.
- Дизель хөдөлгүүрийн их засварын ажил гүйцэтгэсэн байгууллага нь дизель хөдөлгүүрийг ажил үйлчилгээ худалдан авагч байгууллагат тээвэрлэн хүргэж, бульдозерт угсралтын ажил гүйцэтгэнэ.
- Дизель хөдөлгүүрийг асааж тохируулга зүгшрүүлэлтийн ажил гүйцэтгэнэ, 100, 250 мотоцаг ажилласан дизель хөдөлгүүрийн ажиллагааны талаархи мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.
- Засварын ажил гүйцэтгэсэн байгууллага нь ажил үйлчилгээ худалдан авагч талд дизель хөдөлгүүрийн ажиллагааны 100, 250 мотоцагийн үйлчилгээнд солигдох тос, шүүр материалыг нийлүүлэх үүрэгтэй.

- Дизель хөдөлгүүрийг бульдозерт угсрагдан ажиллаж эхэлсэн цагаас эхлэн ажил үйлчилгээ худалдан авагч талаас 12 сараас багагүй буюу 6000 мотоцагийн ажиллагаанд баталгаа шаардана.

Байгууллагад тавих шаардлага:

- Дизель хөдөлгүүрийн их засварын ажил гүйцэтгэх байгууллага нь үйлдвэрлэгч, бульдозерын сэлбэг хэрэгслийг сэргээн засварлах засварын газар, цехтэй, сэлбэг хэрэгсэлд боломжит хамгийн бага үнийг гаргаж хамтран ажиллах чадвартай, худалдааны чиглэлээр албан ёсны сертификат эрхтэй, үйлдвэрийн жинхэнэ бараа, материал нийлүүлдэг төлөөлөгч байгууллага байна.
- Нийлүүлсэн бүх бараа, материал, сэлбэг хэрэгсэл, хийж гүйцэтгэсэн засварын ажил, тоноглолд найдвартай ажиллагааны баталгаа гаргаж өгдөг байх.

Дизель хөдөлгүүрийн пайзны зургийг хавсаргав.

